



**МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ**

Засгийн газрын XIV байр, Чингисийн өргөн чөлөө,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17060
Утас: (976-11) 26 30 51, Факс: (976) 7004 3479,
Цахим шуудан: info@energy.gov.mn

2025.10.24 № 6/3361

танай _____-ны № _____-т

Дотоод аудитын хорооны тогтоол,
тайлан хүргүүлэх тухай

Эрчим хүчний сайдын 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/228 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2024 он, 2025 оны эхний хагас жилийн байдлаар санхүү, худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалт, их засвар, техник, зохион байгуулалтын арга хэмжээний хэрэгжилт, захиргаа, хүний нөөцийн бодлого, дотоод хяналтын хэрэгжилтэд дотоод аудит гүйцэтгэсэн. Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын хорооны 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 25/05, 25/06 дугаар тогтоолоор дотоод аудитын дүн, зөвлөмжийг баталсан байна.

Дотоод аудитын хорооны тогтоол болон зөвлөмжийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж, биелэлтийг 2026 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Хавсралт ... хуудастай

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ЕРЭН-ӨЛЗИЙ

170600003840

ДОТООД АУДИТЫН НЭГЖ: **ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АУДИТЫН ГАЗАР**

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

Аудитын нэр: **Дарханы дулааны сүлжээ ТӨХК-ийн үйл
ажиллагаанд хийсэн дотоод аудит**

Аудитын талаарх товч мэдээлэл

Аудит хийгдсэн объект: ДАРХАНЫ ДУЛААНЫ СҮЛЖЭЭ ТӨХК

Аудитын төрөл: Дотоод аудит

Аудитын хугацаа: 2025.09.22 - 2025.10.20

**Дотоод аудитын
нэгжийн дарга:**

Эрчим хүчний яамны Хяналт-шинжилгээ,
үнэлгээ, дотоод аудитын газрын дарга

Х.БЕКБОЛАТ

Аудит хийсэн:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын шинжээч

Н.АМАРТӨВШИН

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын ахлах мэргэжилтэн

Т.МӨНХЗУЛ

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын мэргэжилтэн

М.ОЮУНДАВАА

АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

2.2 Аудитын цар хүрээ

3. АУДИТЫН ҮР ДҮН

Илэрсэн асуудлууд

4. ДҮГНЭЛТ

НЭГ. ТАНИЛЦУУЛГА

Эрчим хүчний сайдын 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/228 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2024 он, 2025 оны эхний хагас жилийн байдлаар санхүү, худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалт, их засвар, техник, зохион байгуулалтын арга хэмжээний хэрэгжилт, захиргаа, хүний нөөцийн бодлого, дотоод хяналтын хэрэгжилтэд дотоод аудит хийж гүйцэтгэв.

Дотоод аудитыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Х.Бекболат удирдаж, дотоод аудит хариуцсан шинжээч Н.Амартөвшин, ахлах мэргэжилтэн Т.Мөнхзул, мэргэжилтэн М.Оюундаваа нар 2025 оны 09 сарын 22-ны өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 20-ны өдрийг дуустал хугацаанд хийж гүйцэтгэв.

ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН

Эрчим хүчний сайдын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/18 дугаар тушаалаар компанийн 2024 оны техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин батлагдсан. 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/177 дугаар тушаалаар тодотгосон төлөвлөгөөг баталсан. Тодотголоор 1,352.6 сая төгрөгөөр орлогыг нэмэгдүүлсэн байна.

Хүснэгт1. Эдийн засгийн үзүүлэлт

| Үзүүлэлт | хэм.нэгж | 2023 он | 2024 он | | 2025.06.30 | | Харьцуулалт | | |
|-----------------------------|----------|----------|------------|-----------|------------|-----------|-----------------|-----------------------|--------|
| | | | төлөвлөгөө | гүйцэтгэл | төлөвлөгөө | гүйцэтгэл | 2023-2024 онтой | 2024 он төлөвлөгөөтэй | |
| | | | | | | | | дүн | хувь |
| Худалдан авсан ДЭХ | мян.Гкал | 647.4 | 664.3 | 678.8 | 386.6 | 387.1 | 31.4 | 14.5 | 2.2% |
| Нийт орлого: | сая.төг | 14,737.7 | 15,476.4 | 17,566.7 | 9,187.5 | 9,690.1 | 2,829.0 | 2,090.3 | 13.5% |
| Борлуулалтын орло | сая.төг | 13,256.4 | 14,937.9 | 15,582.3 | 9,058.4 | 9,274.7 | 2,325.9 | 644.4 | 4.3% |
| ҮАБус орлого | сая.төг | 1,481.3 | 538.5 | 1,984.4 | 129.1 | 415.4 | 503.1 | 1,445.9 | 268.5% |
| Нийт зардал | сая.төг | 15,112.0 | 17,920.7 | 17,995.0 | 11,203.2 | 9,500.4 | 2,883.0 | 74.3 | 0.4% |
| Цэвэр ашиг, алдагдал | сая.төг | (374.3) | (2,444.3) | (428.3) | (2,015.7) | 162.0 | (54.0) | 2,016.0 | -82.5% |
| Борл.1 төг ногдох зард | төг | 1.03 | 1.16 | 1.02 | 1.22 | 0.98 | (0.0) | (0.1) | -11.6% |
| Нийт ажиллагсад | тоо | 191 | 191 | 189 | 191 | 193 | (2) | (2.0) | -1.0% |
| Нийт авлага | сая.төг | 733.5 | 1,014.1 | 989.9 | 1,014.1 | 1,112.3 | 256.4 | (24.2) | -2.4% |
| Нийт өглөг | сая.төг | 811.7 | 1,007.0 | 647.7 | 1,007.0 | 579.1 | (164.0) | (359.3) | -35.7% |
| Хөрөнгө оруулалт, ИЗ, ТЗБАХ | сая.төг | 1,054.1 | 1,656.5 | 1,379.9 | 305.3 | 298.1 | 325.8 | (276.6) | -16.7% |
| Цалингийн сан | сая.төг | 5,286.1 | 6,832.6 | 6,758.5 | 4,784.9 | 4,409.7 | 1,472.4 | (74.1) | -1.1% |
| Дундаж цалин | мян.төг | 2,306.3 | 2,981.1 | 2,979.9 | 4,175.3 | 3,808.0 | 673.6 | -1.2 | 0.0% |

Дарханы дулааны сүлжээ ТӨХК 2024 онд нийт 664,3 мян.Гкал дулааны эрчим хүч худалдан авч 562,6 мян.Гкал эрчим хүчийг борлуулсан. Нийт 15,476.4 сая төгрөгийн орлоготой, 17,920.7 сая төгрөгийн зардал гарган, 2,444.3 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 17,566.8 сая төгрөгийн орлоготой, 17,995.0 сая төгрөгийн зардал гарган, 428.2 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж төлөвлөгөөт алдагдлыг 2,015.5 сая төгрөгөөр буюу 82.5 хувиар бууруулсан эерэг үзүүлэлттэй байна. Үйл ажиллагааны бус орлого 1,445.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ашигт ажиллагаанд эерэг нөлөө үзүүлсэн боловч захиалгат гэрээт ажлын орлогыг бүрэн төвлөрүүлж чадаагүйн улмаас авлага 275.4 сая төгрөгөөр гэрээт ажлын авлага өссөн. Өглөг төлөвлөснөөс 359.3 сая төгрөгөөр буурсан. Компани нийт 189 ажилтантай ажиллаж, батлагдсан орон тооноос 2 орон тоо дутуу ажилласан. /менежер, засварчин сул орон тоо/ Зорилтот түвшингийн 11 үзүүлэлтээс 10 үзүүлэлтийг хангаж ажилласан бөгөөд зардлын хэтрэлт гарсан нь худалдан авах дулааны эрчим хүч 14.5 мян.Гкал өссөнтэй холбоотой байна.

Эрчим хүчний сайдын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/26 дугаар тушаалаар баталсан зорилтот түвшингийн хүрээнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар 387.1 мян.Гкал дулааны эрчим хүч худалдан авч 0.5 мян.Гкал-р илүү буюу 100,1 хувиар биелүүлсэн байна. Орлогын төлөвлөгөөг 105.4 хувиар буюу 502.5 сая төгрөгөөр давуулан биелүүлж, зардлын төлөвлөгөө 84.8 хувиар хангаж, 1,702.8 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна. Төлөвлөгөөт алдагдлыг 2,177.7 сая төгрөгөөр бууруулсан. 2025 оны зорилтот түвшинд Эрчим хүчний сайдын А/200 дугаар тушаал, А/247 дугаар тушаалаар тодотгол батлуулан мөрдөж ажиллаж байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН /сая.төг/

2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 1,936.7 сая төгрөгийн эргэлтийн, 24,353.4 сая төгрөгийн эргэлтийн бус хөрөнгөтэй ажиллаж өмнөх оны мөн үеэс хөрөнгийн дүн 560.8 сая төгрөгөөр буурсан. Нийт хөрөнгөд мөнгөн хөрөнгө 1,2 хувийг, авлага 3,8 хувийг, бараа материал 2,3 хувийг, эргэлтийн бус хөрөнгө 92.6 хувийг эзэлж байна. Балансын эх үүсвэрийн 2 хувийг өр төлбөр, 98 хувийг эздийн өмч эзэлж байна. Эргэлтийн хөрөнгө оны эхнээс 897.2 сая төгрөгийн өсөлттэй байгаа нь тухайн жилийн их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ хэрэгжих шатандаа байгаа ажлуудын сэлбэг өараа материалын худалдан авалттай холбоотой байна. Оны эцэст бараа материалын дүн бодитоор гарахаар байна.

| Үзүүлэлт | 2023 он | 2024 он | 2025.06.30 | эзлэх хувь | | | өсөлт/ бууралт 2023-2024 |
|-------------------------------------|-----------------|-----------------|-----------------|-------------|-------------|-------------|--------------------------------|
| | | | | 2023 он | 2024 он | 2025.06.30 | |
| ХӨРӨНГӨ | | | | | | | |
| Мөнгө | 572.8 | 325.5 | 98.2 | 2.1% | 1.2% | 0.3% | (247.3) |
| Авлага | 733.5 | 989.9 | 1,112.2 | 2.7% | 3.8% | 3.9% | 256.4 |
| Бараа материал | 624.7 | 614.5 | 1,025.3 | 2.3% | 2.3% | 3.6% | (10.2) |
| Урьдчилж төлсөн зардал | 33.5 | 6.8 | 598.2 | 0.1% | 0.0% | 2.1% | (26.7) |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 1,964.5 | 1,936.7 | 2,833.9 | 7.3% | 7.4% | 10.0% | (27.8) |
| Үндсэн хөрөнгө(цэвэр) | 23,859.5 | 23,326.9 | 24,564.4 | 88.9% | 89% | 86.4% | (532.6) |
| Биет бус хөрөнгө | 1,026.9 | 1,026.5 | 1,026.0 | 3.8% | 4% | 3.6% | (0.4) |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 24,886.4 | 24,353.4 | 25,590.4 | 92.7% | 92.6% | 90.0% | (533.0) |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 26,850.9 | 26,290.1 | 28,424.3 | 100% | 100% | 100% | (560.8) |
| ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ | | | | | | | |
| Богино хугацаат өр төлбөр | 811.7 | 647.7 | 579.1 | 3.0% | 2% | 2% | (164.0) |
| Урт хугацаат өр төлбөр | - | - | - | 0.0% | 0% | 0% | - |
| Нийт өр төлбөрийн дүн | 811.7 | 647.7 | 579.1 | 3.0% | 2% | 2% | (164.0) |
| Эздийн өмчийн дүн | 26,039.2 | 25,642.4 | 27,845.2 | 97.0% | 98% | 98% | (396.8) |
| ӨР ТӨЛБӨР, ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 26,850.9 | 26,290.1 | 28,424.3 | 100% | 100% | 100% | (560.8) |

ХУДАЛДАН АВАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ИХ ЗАСВАР, ТЗБАХ-НИЙ ХЭРЭГЖИЛТ

2024 онд 40 нэр төрлийн 1,656.5 сая төгрөгийн ажил төлөвлөж, гүйцэтгэлээр 100 хувь хэрэгжиж, 276.6 сая төгрөгийн төсөвт өртгийн хэмнэлт гарсан. 2025 оны эхний 9 сарын байдлаар 1,825.8 сая төгрөгийн 41 ажил төлөвлөснөөс 36 ажил хэрэгжиж, 87.8 хувийн биелэлттэй. 5 ажил хэрэгжих шатандаа байна. Үүнд:

- Техник зохион байгуулалтын 2 ажил (тооцоот температурын хэмжилт-хугацаа болоогүй, ПВ№1-д хэт авианы зарцуулалт хэмжигч суурилуулах-тендер шалгаруулалт 2 удаа зарлаж амжилтгүй болж, техникийн тодорхойлолтыг шинэчилж байна.)
- Хөрөнгө оруулалтын 3 ажил (videowall шинэчлэх ажил, програм хангамжийг ERP системд шилжүүлэх, хөгжүүлэх ажил, ачааны автомашины худалдан авалт) хэрэгжих шатандаа байна.

| Утга | 2024 он | | | | 2025.09.30 | | | | Тайлбар |
|------------------------|------------|----------------|-----------|----------------|------------|----------------|-----------|----------------|-----------------------|
| | төлөвлөгөө | | гүйцэтгэл | | төлөвлөгөө | | гүйцэтгэл | | |
| | тоо | дүн сая.төг | тоо | дүн сая.төг | тоо | дүн сая.төг | тоо | дүн сая.төг | |
| Их засвар | 16 | 1,060.4 | 16 | 815.2 | 18 | 1,105.0 | 18 | 948.1 | - |
| ТЗБАХ | 9 | 294.7 | 9 | 273.6 | 7 | 210.7 | 5 | 101.2 | 2 ажил дутуу |
| Хөрөнгө оруулалт | 15 | 301.4 | 15 | 291.1 | 16 | 510.1 | 13 | 81.9 | 3 ажил хэрэгжих шатаа |
| Дүн | 40 | 1,656.5 | 40 | 1,379.9 | 41 | 1,825.8 | 36 | 1,131.2 | |
| Төсөвт өртгийн хэмнэлт | | | | (276.6) | | | | (546.6) | |
| Гүйцэтгэлийн хувь | | | | 100% | | | | 87.8% | |

Их засвар, техник зохион байгуулалт, хөрөнгө оруулалтыг ажил бүр дээр ажлын төлөвлөлтийг тооцоо судалгаан дээр үндэслэж, гарах үр дүн, үр ашгийг тооцож ажилласан сайн туршлага байна.

ХОЁР. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1. Аудитын зорилго:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, компанийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэл санхүүгийн аудит хийх, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж гаргах чиглэлээр тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2. Аудитын хамрах хүрээ:

Дотоод аудитад “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын хэрэгжилтийн хүрээнд 2024 он, 2025 оны эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн үйл ажиллагаа, дулааны эрчим хүчний борлуулалт, худалдан авах ажиллагаа, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний хэрэгжилтийг хамруулав.

2.3 Аудитын арга, аргачлал:

Дотоод аудитыг Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 268 дугаар тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ын хүрээнд доорх хууль тогтоомжийн дагуу дотоод аудитыг хийв. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Компанийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Засгийн газрын болон салбарын сайд, Сангийн сайдын тушаалаар батлагдсан төсөв, санхүүтэй холбоотой журам, дүрэм, заавар аргачлал зэрэг эрхийн актууд
- Яаманд мөрдөгдөж буй эрх зүйн актууд
- НББОУС, СТОУС
- Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт,
- Эрчим хүчний сайдын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/271 дүгээр тушаалаар баталсан “Эрчим хүчний салбарт мөрдөх дотоод аудитын аргачлал”

Аудитын арга зүй, горимын дагуу санхүүгийн тайлан, программаас татсан бүртгэлийн журналын бичилт, дансны хуулгууд, санхүүгийн баримт материалууд, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендер шалгаруулалтын үйл явц, хүний нөөцийн бүртгэл судалгаа, ажилтнуудын анкет хувийн хэргийн бүрдэл, албан тушаалын тодорхойлолт боловсруулалт, нийцэл, ажилтнуудын томилгоо, гүйцэтгэх захирлын тушаал шийдвэрийн хэрэгжилт, төлөвлөлт, бодлого зохицуулалтын албаны ажлын тайлан, техникийн нөхцөл олголт, шинэ хэрэглэгчдийн судалгаа, тооцоо, төлөвлөлтийг үндэслэсэн горим, тооцоо судалгаа, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний үр дүн, хүрэх түвшингийн тооцоо зэрэг цуглуулсан баримт материал, нотлох баримтад дүн шинжилгээ хийх, дахин тооцоолох, түүвэрчлэн шалгах, тулган баталгаажуулах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тодруулга, лавлагаа авах зэрэг аргуудыг ашигласан болно.

ГУРАВ. АУДИТЫН ҮР ДҮН

Дотоод аудитыг компанийн засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын хэрэгжилтийн хүрээнд судалж, дараах асуудлыг илрүүлэн зөвлөмж гаргав.

3.1 Компанийн засаглал

| | |
|--------------------------|---|
| Асуудал 1 | Компанийн дүрэм дэх хувьцааны тоо алдаатай батлагдсан. |
| Асуудлын ангилал | Нөлөө ихтэй |
| Бодит байдал | <p>Дарханы дулааны сүлжээ ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025.06.23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан компанийн дүрмийн 3.1-д хувьцааны тоо алдаатай тусгаж баталсан.</p> <div style="border: 1px solid black; padding: 5px; text-align: center;"> <p>ГУРАВ. КОМПАНИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ХУВЬЦАА</p> <p>3.1.Компанийн зарласан хувьцаа нь 17.920.722,251.5 төгрөгийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 179,9207,223 ширхэг хувьцаатай. Үүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг гагцхүү Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ.</p> </div> <p>Хувьцааны тоо 179,207,223 (нэг зуун далан есөн сая хоёр зуун долоон мянга хоёр зуун хорин гурав) ширхэг хувьцаа батлагдах ёстой байтал 1,799,207,203 ширхэг хувьцаагаар тусгаж, хувьцааны тоог 1,620,000,000 ширхэгээр илүү бүртгүүлсэн байна.</p> |
| Шалгуур | Компанийн тухай хуулийн 16.2.2."Компанийн дүрэмд компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоо, тэдгээрийн төрөл, нэрлэсэн үнэ, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг заавал тусгана." |
| Асуудлын үндсэн шалтгаан | Дүрмийн төслийг нягталж шалгаагүй, Тоон үзүүлэлтийг тоогоор болон үсгээр зэрэг илэрхийлээгүй. |
| Үр нөлөө | Компанийн тухай хууль зөрчигдөх, Компанийн дүрэм алдаатай байх, санхүүгийн тайлан дахь эздийн өмч болон компанийн дүрэм дэх эздийн өмч хооронд зөрүү үүсэх. |
| Зөвлөмж | Төлөөлөн удирдах зөвлөлд: Компанийн дүрэм дэх хувьцааны тоог залруулж, эздийн өмчийн дүнгийн зөрүүтэй байдлыг арилгах |

| | |
|------------------|---|
| Асуудал 2 | <p>2.1 Ажлын байрны тодорхойлолтод тавигдсан шаардлага, шалгуурыг хангаагүй томилгоо хийгдсэн.</p> <p>2.2 Ажлын байрны шинжилгээ хийгдээгүй, ажлын байрны тодорхойлолт зорилтын хүрээнд хийж гүйцэтгэх ажил үүргийн давхардалтай, ажлын байрны зорилтын хүрээнд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, тайлан байхгүй.</p> <p>2.3 Ажилтан, албан хаагчийн хувийн хэргийн баяжилт хангалтгүй.</p> <p>2.4 Ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах журмыг шинэчлэн батлаагүй.</p> |
| Асуудлын ангилал | Нөлөө ихтэй |
| Бодит байдал | <p>2.1 Албан тушаалын тодорхойлолтод нийцээгүй томилгоо хийгдсэн. Үүнд:</p> <p>а) "Хангамжийн мэргэжилтэн" ажлын байрны ерөнхий шаардлага мэргэжил: Менежер гэж заасан байна. Тухайн албан хаагчийн мэргэжил нь: Аялал жуулчлалын мэргэжилтэй хүн томилогдсон байна.</p> <p>б) "Гэрээний мэргэжилтэн" ажлын байрны ерөнхий шаардлага мэргэжил: Дулааны инженер, техникч, эрчим хүчний менежмент гэж заасан байна. Тухайн албан хаагч нь Нягтлан бодогч мэргэжилтэй хүн томилогдсон байна.</p> <p>2.2 Ажлын байрны шинжилгээ хийгдээгүй, ажил үүргийн давхардалтай, ажлын байрны нягтрал сул.</p> <p>с) Захиргаа, удирдлагын хэлтсийн хүний нөөцийн бодлого төлөвлөлтийг сайжруулах эхний алхам нь ажлын байрны шинжилгээ хийх ажил зайлшгүй шаардлагатай. Ажлын байрны шинжилгээгээр жилд 1 ажилтан 220-225 хүн/өдөр зарцуулах хэмжээний ажил үүрэг гүйцэтгэх ёстой. Компанид ажлын байрны шинжилгээ хийж байгаагүй учраас хэрхэн хийх ойлголтгүй байсан тул аудитын явцад ажлын байрны шинжилгээ хийх загвар ажлын хүснэгтийг өгч, заавар зөвлөгөө өгч ажиллав.</p> <p>Түүврээр 6 ажлын байрыг сонгож, загварын хүрээнд шинжилгээ хийлгэсэн.</p> <p>I. Худалдаа авах ажиллагааны менежер нь ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах 230 хүн/өдөр;</p> <p>II. Техник хангамжийн инженер нь байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах 241.5 хүн/өдөр;</p> <p>III. Хяналт удирдлагын систем автоматикийн инженер нь байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах 422.8 хүн/өдөр;</p> |

- IV. Хангамжийн мэргэжилтэн нь байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах 241 хүн/өдөр;
- V. Хуулийн мэргэжилтэн нь байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах 235 хүн/өдөр;
- VI. Хуулийн зөвлөх нь байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах 824 хүн/өдөр гэж гаргасан байна.

Шинжилгээний дүнгээс харахад Хуулийн зөвлөхийн ажлын байранд 824 хүн/өдрөөр тооцож гаргаж байгаа нь үндэслэлгүй тооцоолол, эсвэл ажилтанд хэт их ачаалал үүсгэж байгаа дүгнэлтэд хүргэж байна. Ажлын байрны шинжилгээг ямар судалгаа тооцоогоор нэг хүн дээр ийм олон хүн/өдөр зарцуулахаар гаргасан эсэх нь тодорхойгүй байгаа тул Ажлын хэсэг томилж, компанийн хэмжээнд ажлын байрны зураг авалт, шинжилгээ хийж, цэгцлэх шаардлагатай.

d) Чиг үүргийн давхардал:

| № | Хийгдэх ажил | Давхардсан ажлын байрууд |
|----|---|--|
| 1. | Шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаарх мэдээллийг тухай бүр удирдах албан тушаалтан, ажилтнуудад өгч байх | Хуулийн зөвлөх, |
| 2. | Компанийн хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн актын биелэлтэд хяналт тавьж, түүнийг шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулж байх | |
| 3. | Айл өрх, аж ахуй нэгжтэй байгуулах дулааны эрчим хүчээр хангах гэрээний биелэлтэнд хяналт тавих, гэрээний хууль зүйн үндэслэлийг тогтоох, хянах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах | Хуулийн мэргэжилтэн |
| 4. | Ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийх эрсдлийг бууруулах ажил | Хуулийн мэргэжилтэн, Гэрээний мэргэжилтэн |
| 5. | DDS" аппын хэрэглээг нэмэгдүүлэх талаар санал гаргах | |

e) Ажлын байрны тодорхойлолт зорилтын хүрээнд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, тайлан байхгүй тул түүврээр авсан 13 ажлын байранд төлөвлөгөө, тайлан гаргах загвар хүснэгт өгч, тайланг гаргуулж ажиллав. Тухайн ажлыг хийж гүйцэтгэсэн нь тодорхойгүй төлөвлөгөөг шууд хуулж бичсэн нийтлэг алдаа гарч байна.

f) Ажлын байрны тодорхойлолтод заасан боловч хийж хэрэгжүүлээгүй ажил байна. Тухайлбал: Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийж эрсдэлийн бууруулах гэсэн заалт орсон байна.

2.3 Анкет, хувийн хэргийн баяжилт:

Аудитын явцад ажилтны хувийн хэрэгтэй танилцахад материал дутуу, баяжилт хийгдээгүй, хувийн хэргийн бүрдэл дутуу нөхөж үзүүлж ажиллаж байсан. Тухайлбал:

a) Хуулийн мэргэжилтний мэргэжил англи хэлний орчуулагч гэх үндэслэлээр аудитын шалгалтын явцад хувийн хэрэгтэй танилцаад ажлын байрны тавигдах шаардлага хангахгүй гэж үзсэн боловч 2015-2018 онд "Эрх зүйч мэргэжлээр төгссөн" бакалаврын дипломыг 2025 оны 10-р сарын 9-ний өдөр гаргаж өгөв.

b) Гэрээний мэргэжилтний мэргэжил газар зохион байгуулагч гэх үндэслэлээр аудитын шалгалтын явцад хувийн хэрэгтэй танилцаад ажлын байрны тавигдах шаардлага хангахгүй гэж үзсэн боловч дулааны шугам сүлжээний техникч мэргэжлээр төгссөн дипломыг 2025 оны 10-р сарын 13-ны өдөр телеграммаар ирүүлсэн. Анкетын баяжилт тухай бүр хийгдээгүй байна.

2.4 Гүйцэтгэх захирлын 2015.03.23-ны өдрийн 49 дүгээр тушаалаар баталсан Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, инженер, техникийн ажилтныг сонгон шалгаруулах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах тухай журмыг мөрдөн ажиллаж байна. Засгийн газрын 2023.03.07-ны өдрийн 86 дугаар тогтоолоор "Төрийн өмчийн хуулийн этгээдийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нийтлэг журам"-ыг баталсан. Уг журмын 1.3."Хуулийн этгээд нь энэ нийтлэг журамд нийцүүлэн үйл ажиллагааны чиглэл, онцлог, цар хүрээг харгалзан ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах журмыг батална." гэж заасны дагуу нээлттэй сонгон шалгаруулалтын журмыг шинэчлэн батлаагүй байна.

Шалгуур

- Засгийн газрын 2023.03.07-ны өдрийн 86 дугаар тогтоолоор "Төрийн өмчийн хуулийн этгээдийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нийтлэг журам".
- 2025.04.02-ны өдрийн А/66 тоот "Дархан Дулааны Сүлжээ" ТӨХК-ийн ажилтны хувийн хэрэг хөтлөх журам;
- Ажлын байрны тодорхойлолт

| | |
|--------------------------|--|
| Асуудлын үндсэн шалтгаан | Ажлын байрны шинжилгээ хийдэггүй учраас тухайн ажлын байранд хийгдэх ажил үүргийг оновчтой тодорхойлоогүй; Ажлын байрны тодорхойлолтод тавигдах шалгуур, шаардлагыг хангаагүй; Ажиллагсад ажлын байрны тодорхойлолтын зорилго, зорилтын хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө гаргаж, тайлагнадаггүй. |
| Үр нөлөө | Хүний нөөцийн бодлого алдагдах, боловсон хүчний дутагдалд орох, ажлын хийдэл, хэт ачаалал үүсэх. |
| Зөвлөмж | 1. Ажлын хэсэг томилон “Ажлын байрны шинжилгээ”-г яаралтай хийж, ажлын байрны чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын нягтралыг сайжруулах; 2. Ажилтан бүр тухайн жилийн ажлын төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг ханган тайлагнаж хэвших; 3. “Жилийн үйл ажиллагааны болон сарын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлс олгох журам”-д ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийн хүрээнд хийгдэх ажлын гүйцэтгэл, хэрэгжилтээр үр дүнгийн нэмэгдэл хөлс олгох мөн ажлын байрны тодорхойлолтын зорилго, зорилтын дагуу хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, тайлангийн загвар маягт, төлөвлөгөөний гүйцэтгэлийг дүгнэх аргачлал зэргийг нэмэлт өөрчлөлтөөр тодорхой оруулах; 4. Ажлын байрны сонгон шалгаруулалтыг нээлттэй ил тод явуулж ажлын байрны тодорхойлолтод заасан тавигдах шаардлагад нийцсэн мэргэжилтэй боловсон хүчнийг томилох; 5. Ажилтан, албан хаагчдын анкет, хувийн хэрэг, баримт бичгийг бүрдлийг хангаж, тухай бүр баяжуулалт хийж байх. 6. Сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах журмыг шинэчлэн батлах, мөрдөх. |

| | |
|--------------------------|--|
| Асуудал 3 | Гэрээ, тушаал шийдвэрийг алдаатай боловсруулсан. |
| Асуудлын ангилал | Нөлөө ихтэй |
| Бодит байдал | Ноён Өндөр констракшн ХХК гэрээ: - Гэрээний 4.2. “Захиалагч гэрээт ажил бүрэн дуусмагц талууд акт үйлдэн төсвийн санхүүжилт хийгдсэн тухайн өдөрт багтаан бүрэн хэмжээгээр ажил гүйцэтгэгчийн дансанд саадгүй шилжүүлнэ.” - 4.3. “Ажлын хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд алданги тооцно.” гэж заасан. Энэ 2 заалтын хувьд хоорондоо нийцэхгүй, салаа утгыг агуулсан. Гүйцэтгэгч Дарханы дулааны сүлжээ ТӨХК нь захиалагч Ноён өндөр констракш ХХК-ийн дансанд УТХО-ын санхүүжилт орсон эсэхийг мэдэх боломжгүй. Үүний улмаас алдангид холбоотой 4.3 дахь заалтыг хэрэгжүүлэх боломжгүй томъёолол тусгасан. Сигма Эс ХХК-ийн гэрээ: - Гэрээний 1.5. “Ажил дуусах хугацаа 2024.11.14” - Гэрээний 4.2. “Ажлын хөлсний урьдчилгаа төлбөр болох 30,234,790 төгрөгийг 2024.10.21-нд 15,000,000 төгрөг, 2024.11.15-нд 15,234,790 төгрөгийн төлбөрийн график” тусгасан. Гэрээний хугацаа дууссан байхад урьдчилгаа төлбөр гэж заасан нь гэрээ боловсруулалтын алдааг харуулж байна. Гэрээт ажил дууссан байхад урьдчилгаа төлбөр хийгдэхгүй нөхцөл үүссэн. Тушаал шийдвэр: - Гүйцэтгэх захирлын 2024.10.07-ны өдрийн а/85 тушаалын 2-т энэ тушаалыг 2025.10.08-ны өдрөөс эхлэн мөрдөхөөр, 3-т 2015.12.24-ний өдрийн 226 дугаар тушаалыг хүчингүй болгохоор заасан. Гэтэл уг тушаалыг мөрдөж эхлэх огноог алдаатай гаргасан. /3 огноо байгаа нь алдааг тодруулж, ойлгомжгүй байдал үүсгэсэн./ - Гүйцэтгэх захирлын 2024.05.13-ны өдрийн “Нэмэгдэл олгох тухай” а/51 тушаалын үндэслэл хэсэгт утга агуулга алдаатай, үндэслэх заалт байхгүй, ойлгомжгүй боловсруулсан тушаалыг баталсан. “... Дарханы дулааны сүлжээ ТӨХК-ийн захиргаа болон Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан дэх заалтыг ...” гэж тусгасан байна. |
| Шалгуур | Хуулийн зөвлөх “Албан тушаалын тодорхойлолт”-ын ажлын байрны үндсэн зорилт: компанийн үйл ажиллагааг мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд явуулах, иргэн, аж ахуйн нэгжтэй байгуулах гэрээг хуулийн хүрээнд хийх, 1.2.”Гүйцэтгэх захирлын тушаалын хууль зүйн үндэслэлийг хууль тогтоомжид бүрэн нийцүүлэх. |
| Асуудлын үндсэн шалтгаан | Гэрээ, тушаал шийдвэрийн төсөл боловсруулалтын шатанд сайтар танилцаж, хянаагүй. Албан тушаалын тодорхойлолтоор хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт хангаагүй. |
| Үр нөлөө | Гэрээ, эрх зүйн акт, баримт бичгүүд алдаатай боловсруулагдах, Компанид хохирол учруулах /төлбөр тооцооны хугацаа гадны байгууллагад нийцтэй болох, гэрээний үүргийн биелэлт хангуулах нөхцөл боломж алдагдах, шүүхийн шатанд шаардлага хангахгүй эрх зүйн баримт бичиг баталсан байх зэрэг/ |
| Зөвлөмж | Баримт бичгийн боловсруулалт, хяналтыг чанаржуулах Эрх зүйн үндэслэл бүхий захирамжлалын баримт бичиг-тушаал шийдвэр батлах. |

3.2 Эрсдэлийн удирдлага

| | |
|--------------------------|--|
| Асуудал 4 | 2.1 НББОУС зөрчигдсөн. Дулааны борлуулалтын өртгийг үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртгийн бүртгэлээр хөтөлсөн. 2.2 НБББББ-т шинэчилсэн найруулга хийгээгүй, 2019 онд баталсан баримт бичгийг мөрдөж байна. |
| Асуудлын ангилал | Нөлөө ихтэй |
| Бодит байдал | <p>НБББББ-ийн 4.10.1 Зардлын бүртгэлийн бодлогын 6.2."Орлого үр дүнгийн тайланд дараах ангиллын дагуу холбогдох зардлын талаарх мэдээллийг тайлагнана. а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг, б)Үйл ажиллагааны зардал: удирдлагын зардал, борлуулалт маркетингийн зардал. <u>Борлуулсан бүтээгдэхүүний өртөг: борлуулалтын орлогод ногдох борлуулсан буюу түгээсэн дулаан үүр, усны өртөгт хамаарах бүхий л зардлууд багтсан байна.</u>" гэж заасан.</p> <p>Дарханы дулааны сүлжээ ТӨХК нь үйлдвэрлэлийн компани биш бөгөөд борлуулалтын үйл ажиллагаа эрхэлдэг. Компанийн үйл ажиллагааны чиглэлийг компанийн дүрмийн 2.1-д дараах байдлаар тодорхойлсон.</p> <div data-bbox="281 622 1413 831" style="border: 1px solid black; padding: 10px; text-align: center;"> <p>ХОЁР. КОМПАНИЙН ҮНДСЭН ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ХУГАЦАА</p> <p>2.1.Компанийн үндсэн зорилт нь дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн хүрээнд Дархан-Уул аймгийн төвийн аж ахуйн нэгж, байгууллага, орон сууцны байрыг дулааны эрчим хүчээр найдвартай хангахад оршино.</p> </div> <p>Гэтэл компани үйлдвэрлэлийн компанийн "Дуусаагүй үйлдвэрлэлийн дансдууд"-аар дамжуулж бүртгэл хөтөлж байна. Худалдан авсан дулааны эрчим хүчийг ББӨртөг дансанд бүртгэх шаардлагатай. Мөн түүнчлэн НБББББ-т үйлдвэрлэлийн зардал гэдэг томъёолол оруулсан байгаа нь тус компанийн үндсэн үйл ажиллагаатай холбоогүй учраас баримт бичгийг өөрчлөх шаардлагатай.</p> <p>2.2 Гүйцэтгэх захирлын 2019.04.19-ний өдрийн А/68 тоот тушаалаар "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" батлагдаж, мөрдөж эхэлсэн байна. НБББББ-ийг хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэлтэй холбоотой өөрчлөлт, шинэчлэн найруулга хийгдээгүй.</p> <p>Цалин хөлсний бүртгэл бүлгийн "Дундаж цалин хөлс тооцох" хэсэгт Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын 2005.05.05-ны өдрийн 55 дугаар тушаалыг мөрдлөг болгоно гэж заасан. Хөдөлмөрийн хууль 2021.07.02-нд шинэчлэгдсэн. ХНХСайдын 2021.12.06-ны өдрийн А/192, 2022.03.17-ны өдрийн А/49 дүгээр тушаалууд гарч дундаж цалин хөлс тооцох журам, аргачлал өөрчлөгдсөн.</p> |
| Шалгуур | НББОУС-ын зардлын бүртгэл, НББББББ-ийн зардлын бүртгэл 4.10.1.6 Санхүүгийн тайланд тусгах |
| Асуудлын үндсэн шалтгаан | НББББББ ойлголтын зөрүү үүсгэх хэмжээнд боловсруулагдсан. Зардлын бүртгэлийн бүлэгт үйлдвэрлэлийн зардал гэдэг нэр томъёо тусгасан. Мөн захиалгат ажлын бүртгэлийн хэсэгт Дуусаагүй үйлдвэрлэлийн данс ашиглахаар заасан зэрэг нь нөлөөлсөн. |
| Үр нөлөө | Бүртгэлийн стандарт зөрчигдсөн. Хууль тогтоомжийн шинэчлэлтэй уялдуулан нэмэлт өөрчлөлт оруулж, компанид мөрдөгдөх эрх зүйн актуудыг боловсруулаагүй. |
| Зөвлөмж | Өртгийн бүртгэлийн стандартын дагуу хөтлөх, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн найруулах. Ажлын хэсэг байгуулах замаар шийдвэрлэх боломжтой. |

| | |
|------------------|--|
| Асуудал 5 | Үйл ажиллагааны бус орлого төвлөрүүлэлт хангалтгүй. 5.1 Техникийн нөхцөл олголтын төлбөрийн орлого дутуу төвлөрүүлсэн. 5.2 Гадны байгууллагуудад үзүүлсэн гэрээт ажлын төлбөр нь хийгдээгүй 273,727,058 төгрөгийн авлага үүсгэсэн. Уг авлагад тооцогдох 40,452,326 төгрөгийн алдангийг тооцож, нэхэмжлээгүй. Компанийн зүгээс тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна. |
| Асуудлын ангилал | Нөлөө их |
| Бодит байдал | 5.1 Техникийн нөхцлийн орлого: 2024 онд нийт 226 техникийн нөхцлийн хүсэлт ирсэнээс Төлөвлөлт, бодлого зохицуулалтын алба судалж, горим тооцоо хийснээр 52 хүсэлтийг олгоогүй |

/техникийн боломжгүй, дахин зөвшилцөх, хүчингүй болгох зэрэг/ 174 техникийн нөхцөл олгосон. Үүнээс 33 техникийн нөхцлийн 5,5 сая төгрөгийн орлого төлөгдөөгүй. 2025.09.30-ны байдлаар 152 хүсэлтийг судалж 95 техникийн нөхцөл олгосон. 30 техникийн нөхцлийн 5,0 сая төгрөгийн орлого төвлөрөөгүй байна.

| Агуулга | 2024 | 2025.09.30 |
|--|------|------------|
| Хүсэлт ирүүлсэн | 226 | 152 |
| Техникийн нөхцөл олгосон | 174 | 95 |
| Техникийн нөхцлийн төлбөр төлсөн | 141 | 64 |
| Техникийн нөхцлийн төлбөр төлөөгүй, техникийн нөхцлөө аваагүй | 19 | 15 |
| Техникийн нөхцлийн төлбөр төлөөгүй, баталгаажсан техникийн нөхцлийг эзэнд нь олгосон | 14 | 15 |
| Сүлжээнд холбогдсон шинэ хэрэглэгчийн тоо | 92 | 42 |

Аудитын явцад 3 нэхэмжлэхийг цахимд шивсэн ба төлөгдөөгүй бүх харилцагчдын нэхэмжлэхийг шивж, төвлөрүүлэхийг зөвлөж ажиллав.

5.2 Алдангийн орлого: 2024 онд гадны байгууллагад гэрээт ажил гүйцэтгэсэн гэрээний төлөгдөөгүй 193,727,058 төгрөгийн авлагад тооцогдох алдангийн нийт дүн 35,157,326 төгрөг үүссэн байна. Гэрээт ажлыг Дарханы дулааны сүлжээ ТӨХК холбогдох материалын зардал, техник, ажиллах хүчний зардал гаргаж бусдын ажлыг хугацаанд нь гүйцэтгэсэн боловч доорх 3 харилцагч өнөөдрийг хүртэл төлбөр тооцоогоо хийж дуусаагүй, гэрээний үүргээ биелүүлээгүй байна. Компанийн зүгээс 2025.02.18-ны өдрийн 1/202 тоот албан бичгийг хүргүүлснээс өөр ямар нэгэн арга хэмжээг аваагүй. Алдангийн тооцоо үүсгээгүй, нэхэмжлээгүй байна.

“Мөнхтшир хан” ХХК-тай 2024.09.09-нд дулааны шугам угсрах 81/2024 тоот АГГ байгуулсан. Гэрээний дүн 182,038,700 төгрөг. ГДАкт 2024.10.30 баталгаажсан. Гэрээний 4.2-т зааснаар 3 хоногт 25% урьдчилгаа төлбөр 45,509,675 төгрөгийг төлөх байтал 2024.10.21-нд 30,000,000, 2024.09.29-нд 20,000,000 төгрөг, 2025.09.16-нд 32,000,000 төгрөгийг шилжүүлсэн. Гэрээний үлдэгдэл 100,038,700 төгрөгийн авлагатай, өнөөдрийг хүртэл гэрээний үүргийн биелэлт хангагдаагүй байна. Тооцвол зохих алдангийн нийт дүн **17,935,360** төгрөг.

“Принц иго” ХХК-тай 2024.09.20-нд дулааны шугам хоолой угсрах 82/2924 тоот АГГ-ний дүн 187,688,358 төгрөг. Гэрээ дүгнэсэн акт 2024.10.19 баталгаажсан. Авлагын үлдэгдэл 7,688,358 төгрөг байна. Тооцвол зохих алдангийн дүн **2,912,474** төгрөг. /3 удаа хэсэгчилсэн төлөлттэй/

Сигма Эс ХХК-тай 2024.10.14-нд дулааны шугам хоолой угсрах 86/2024 тоот АГГ байгуулсан. Гэрээний дүн 161,234,790 төгрөг. Гэрээ дүгнэсэн акт 2024.10.30-нд баталгаажсан. Гэрээний 4 удаагийн хэсэгчилсэн төлбөрөөр нийт 75,234,790 төгрөгийн төлөлт хийгдэж, 86,000,000 төгрөгийн авлагатай байна. Тооцвол зохих алдангийн нийт дүн **14,309,492** төгрөг байна.

2025 онд 2 гэрээт ажил хийж гүйцэтгэсэн. Гэрээ дүгнэсэн актаар баталгаажсан. Үүнд:

Буян импекс ХХК, ЦЦТО ХХК: 2025.06.05-ны өдрийн 69/2025 тоот АГГ-ний дүн 260,000,000 төгрөг. 4 удаагийн хэсэгчилсэн төлөлтөөр 180,000,000 төгрөг орсон. Үлдэгдэл авлага 80,000,000 төгрөг. Гэрээний дагуу тооцох алданги **5,295,000** төгрөг байна. /Алдангийн тооцоог аудитын хугацаа болох 2025.10.08-ны өдрөөр тооцсон болно. Тооцооллыг хавсаргав./

| | |
|--------------------------|---|
| Шалгуур | Төсвийн хуулийн 6.4.8. "Төсвийг зохистой удирдаж <u>авлага</u> , өр төлбөр үүсгэхгүй байх." Гэрээний холбогдох заалтууд |
| Асуудлын үндсэн шалтгаан | Хяналт сул, ажлын уялдаа холбоог хангаж ажиллаагүй, Хуулийн зөвлөх нь ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийн хүрээнд гэрээний үүргийн биелэлтийг хангуулах арга хэмжээ авч ажиллаагүй. |
| Үр нөлөө | Үйл ажиллагааны бус орлого олох боломж алдах, Ашиглан үүсэх эрсдэлтэй. |
| Зөвлөмж | <ul style="list-style-type: none"> - Техникийн нөхцлийн орлого төвлөрүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, - Төлбөрийн е-нэхэмжлэхийг шивж, төлөлт хийгдсэний дараа Техникийн нөхцлийг гарт олгох, сүлжээнд холбох, - Захиалагч талын гэрээний үүргийн биелэлтийн хангуулах тал дээр зохих арга хэмжээг яаралтай эхлүүлэх. |

| | |
|-------------------|--|
| Асуудал 6 | 2024, 2025 оны их засварын ажил гүйцэтгэсэн бригад ахлагч нарт 17.7 сая төгрөгийн нэмэгдэл хөлс олгож, төлөвлөгөөнд тусгагдаагүй зардал гарсан. |
| Асуудлын ангилал | Нөлөө их |
| Бодит байдал | Гүйцэтгэх захирлын 2024.05.13-ны өдрийн а/51, 2025.05.19-ний өдрийн а/79 дүгээр тушаалаар их засварын ажил гүйцэтгэсэн бригадын ахлагч нарт 10-20 хувийн нэмэгдэл олгохоор баталсан. 2024 оны зорилтот түвшинд 6,629.7 сая төгрөг, 2025 онд 8,434.2 сая төгрөгийн цалингийн зардал төлөвлөсөн бөгөөд уг зардалд засварын ажил амжилттай гүйцэтгэж, ур чадвартай ажилласан ажилтнуудыг урамшуулан олгох нэмэгдэл хөлсийг огт тооцож төлөвлөөгүй. Гэтэл компани 2024 онд 23 ажилтанд 8.2 сая төгрөг, 2025.09.30-ны байдлаар 22 ажилтанд 9.5 сая төгрөг, нийт 17.7 сая төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон байгаа нь батлагдсан төсөвт тусгагдаагүй зардал гаргаж, төсвийг үр ашиггүй зарцуулсан. Энэ хэмжээгээр цалингийн зардлын хэмнэлт гарах боломжтой байсан. Нөгөө талаас төлөвлөлтийг иж бүрэн, аливаа зардлыг орхигдуулахгүйгээр тооцоолох шаардлагатай гэдэг дүгнэлтэд хүргэж байна. |
| Шалгуур | Төсвийн тухай хуулийн 6.4.1."Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; Эрчим хүчний сайдын тушаалаар батлагдсан зорилтот түвшингүүд |
| Асуудлын шалтгаан | Зорилтот түвшингийн төлөвлөлтөд зардал орхигдуулсан. |
| Үр нөлөө | Төлөвлөгөөнд тусгагдаагүй зардал гаргах, зардлын хэтрэлтэд хүргэх эрсдэлтэй. |
| Зөвлөмж | Төлөвлөлтийг иж бүрэн, хоцорсон зардал гаргахгүйгээр боловсруулах |

| | |
|------------------|--|
| Асуудал 7 | Үндсэн хөрөнгийн алдаатай бүртгэл хөтлөгдсөн. Үүнд: 2 хөрөнгийн ангилал болон тоо хэмжээг зөрүүлж бүртгэсэн, 1 хөрөнгийг бүртгэлд тусгаагүй алдаа илэрсэн. |
| Асуудлын ангилал | Нөлөө бага |
| Бодит байдал | <ul style="list-style-type: none"> - Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 14.4.1, 14.4.2 дахь заалтыг зөрчиж, 1 хөрөнгийг бүртгэлд тусгаагүй 5 жил өнгөрөөсөн. Үүнд: Дархан сумын Засаг даргын 2020.05.27-ны өдрийн 127/2 тоот захирамжийн дагуу Дарханы дулааны сүлжээ ТӨХК-д 4502005566 дугаар бүхий 9136 м.кв газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлж, газрын эрхийн Э-2002001173 дугаарт бүртгэлтэй, №0000109431 тоот Аж ахуйн нэгжийн газар эзэмших эрхийн гэрчилгээг олгосон байна. Газрын гэрчилгээ гарснаас хойш 5 жил болсон байхад компанийн санхүүгийн тайланд газрын эрхийг өнөөдрийг хүртэл бүртгэлд тусгаагүй байна. - 2023 оны 12 сард үндсэн хөрөнгийн ангилал зөрүүлэн бүртгэж, "Амины орон сууцны зураг" 47.2 сая төгрөгийг Газар эзэмших эрх дээр бүртгэн, 23.8 сая төгрөгийн хорогдол тооцсон. НББОУС-аар "Газар" гэсэн хөрөнгөд элэгдэл тооцдоггүй. Иймд 47.2 сая төгрөгийг АОС зургийн бүртгэлийг залруулж, Биет бус хөрөнгө рүү шилжүүлэх бичилт хийх нөхцөл байдал үүссэн. - Приус-41 автомашины тоог алдаатай бүртгэлд тусгасан. 2024 онд тендер шалгаруулалтаар 107.0 сая төгрөгийн 2ш автомашин худалдан авсан байхад үндсэн хөрөнгөд орлогод авахдаа 4 ш гэж бүртгэсэн. |
| Шалгуур | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: Үүнд 14.4.1.аж ахуйн <u>бүх ажил, гүйлгээ</u> ; 14.4.2.бүх <u>хөрөнгө</u> , хөрөнгө оруулалт, авлага; НББОУС-16 Үндсэн хөрөнгө |
| Үр нөлөө | Хууль, тогтоомж, стандарт зөрчигдөх эрсдэлтэй. |
| Зөвлөмж | НББ-ийн хууль болон НББОУС-ыг мөрдөх, НББ-ийн дээрх 3 алдаа, зөрчлийг арилгах хүрээнд бүртгэлд тусгагдаагүй байгаа "Газрын эрх-"ийг үнэлж бүртгэх, хөрөнгийн ангилал болон тоо хэмжээний залруулах бичилтүүдийг даруй хийх шаардлагатай. |

| | |
|------------------|--|
| Асуудал 8 | Тээврийн хэрэгслүүдэд хяналтын GPS системийг суурилуулсан боловч, шатахууны зарцуулалт, тооцоо бодолтод түлшний хяналтын системийг ашиглаагүй, шатахууны зарцуулалтыг бууруулах, норм шинэчлэн тогтооход чиглэсэн арга хэмжээ авч ажиллаагүй байна. |
| Асуудлын ангилал | Нөлөө ихтэй |
| Бодит байдал | Компанийн үндсэн хөрөнгийн бүртгэлд 15.0 сая төгрөгийн GPS системийн төхөөрөмжийг худалдан авч үндсэн хөрөнгөд бүртгэж, 15 тээврийн хэрэгсэлд суурилуулсан байна. Дотоод аудитын явцад GPS системийн 2025 оны 4 дүгээр сарын тайланг татан авч, дүн шинжилгээ ажиллалаа. Уг системийг Ерөнхий инженер хөдөлмөрийн аюулгүй байдлын хүрээнд жолоочид хурдны хязгаарыг баримталж байгаа эсэх, тухайн өдрийн гүйцэтгэх ажлын хүрээний маршрутын хүрээнд зорчиж байгаа эсэхийг хянаж ашигладаг байна. Харин тухайн тээврийн хэрэгслүүдийн шатахууны тооцоо бодолтод GPS системийн тайланг ашиглахгүй байна. |

| <p>Системийн тайлангаар шатахууны цэнэглэлт, алдагдал, үлдэгдэл, туулсан км, хугацааны дэлгэрэнгүй мэдээлэл, мэдрэгчийн статистик зэрэг чухал мэдээллүүд гарч байна. Эдгээр мэдээлэл дээр үндэслэн санхүүгийн анхан шатны шатны баримт-жолоочийн замын хуудастай тулгалт хийж үзэхэд дараах байдлаар зөрүү үүсч байна.</p> | | | | | | | |
|--|---|---------------------|-----------------|------------------|---------------------|-----------------|----------------------------------|
| Дуаар | Машин марк | GPS систем | | | Замын хуудас | | Дотоод аудитаар тооцсон зөрүү |
| | | Цэнэглэлт /литр/ | Туулсан /км/ | Зарцуу лалт л | Цэнэглэлт /литр/ | Туулсан /км/ | Туулсан км |
| 75-33 ДАР | Пронтер | 113.41 | 818.99 | 12.07 | 120 | 1032 | 213 |
| 26-32 ДАА | Автобус | 114.45 | 361.96 | 25.28 | 100 | 483 | 121 |
| 16-54 ДАХ | Зтн кран | 48.68 | 291.7 | 21.11 | 50 | 320 | 28 |
| ДҮН | | | | | | | 362 |
| <p>Дарханы дулааны сүлжээ ТӨХК нь 2019 онд “Автомашин, механизмын шатахуун, сэлбэг хэрэгслийн жишиг норм” баталсан бөгөөд өнөөдрийг хүртэл шинэчлэгдээгүй байгаа. Шинээр авсан машинуудад батлагдсан норм байхгүй. Дээрх түүвэрт хамрагдсан машинуудын шатахууны нормыг баталсан тушаал шийдвэр гараагүй учраас шатахууны зарцуулалтад дүн шинжилгээ хийх боломжгүй байна. Шинэ тээврийн хэрэгсэл ирэхэд Ажлын хэсэг гарч, тухайн машины банкыг дүүргэж 100км зарцуулах нормыг тодорхойлсноор шатахууны зарцуулалтыг тооцож байна. Захирлын тушаалаар батлагдсан нэгдсэн норм байхгүй.</p> <p>Түлшний хяналтын системийн тайлан, автомашины спидометрийн заалт болон нормоор тооцсон шатахууны зарцуулалт хоорондын зөрүүгийн шалтгааныг тогтоох, зүй бус зарцуулалт байгаа эсэхийг илрүүлэхэд чиглэсэн хяналтын арга хэмжээ авч ажиллаагүй. Тус төхөөрөмжийг зориулалтын дагуу үр дүнтэй, бүрэн дүүрэн ашиглахгүй байна.</p> <p>GPS-н лицензын төлбөрт сард 371,800 төгрөг, жилд 4,461,600 төгрөг төлж байгаа нь үр ашиггүй зардал гаргаж байгаа дүгнэлтэд хүргэж байна. Компанийн 2024 оны шатахууны зардал 53,9 сая төгрөг, 2025 оны хагас жилд 25,8 сая төгрөг зарцуулсан ба шатахуун зарцуулалтыг ухаалаг системд тулгуурлан хянаж, нормыг шинэчилж мөрдөж ажилласан бол тодорхой хэмжээнд шатахууны зардлыг бууруулах боломжтой байсан. Иймд тус системийг нийлүүлэгч “Гайхам” ХХК-тай хамтарч ажиллаж, холбогдох тохиргоо, шинэчлэлийг хийлгэж, төхөөрөмжийг үр дүнтэй ашиглах зайлшгүй нөхцөл байдал үүссэн байна.</p> | | | | | | | |
| Шалгуур | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.1.зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах; 4.2.8.цахимжуулалт болон инновацыг дэмжих замаар үрэлгэн байдлын эсрэг саад тотгорыг арилгах; GPS системийн тайлан | | | | | | |
| Асуудлын шалтгаан | Өндөр өртөгтэй, ухаалаг системийг шатахууны зарцуулалтын хяналтад бүрэн ашиглаагүй, Хяналтын системээр гарсан мэдээлэлд үндэслэн шатахуун зарцуулалт тооцоогүй, Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг аваагүй. | | | | | | |
| Үр нөлөө | Шатахууны зарцуулалт бууруулах, хянах боломжийг алдах, Үр ашиггүй зарцуулалт гарах. | | | | | | |
| Зөвлөмж | <ul style="list-style-type: none"> - GPS системийн түлшний тайлан болон ажлын зураг авалтыг үндэслэн, шатахуун зарцуулалтын норм шинэчлэх; - Шатахууны норм шинэчлэлтийн үр дүн, зардлын хэмнэлтийн эдийн засгийн үр ашгийг тооцох. | | | | | | |

3.3 Дотоод хяналтын хэрэгжилт

| | |
|-------------------------|---|
| Асуудал 9 | Дотоод хяналт шалгалтын зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй. |
| Асуудлын ангилал | Нөлөө ихтэй |
| Бодит байдал | <p>Дотоод хяналтын алба нь 2024 онд хяналт шалгалтаар нийт 93 зөрчил илрүүлсэн. Үүнээс 78 зөрчлийг арилгасан байна. 83.8 хувийн биелэлттэй. Шийдвэрлээгүй 15 зөрчил байна. 2024 онд Холбогдох алба, хэлтсүүдэд нийт 109 зөвлөмжийг хүргүүлсэн. Үүнээс 49 зөвлөмжийн биелэлт хангагдсан 39.4 хувьтай биелүүлсэн байна. Тухайлбал: Төлөвлөлт бодлого зохицуулалтын алба, Дулаан дамжуулах алба, Дулаан түгээх хангах алба зэрэг албуудад 2024 онд хяналт шалгалтын мөрөөр илэрсэн зөрчлийг арилгах тухай тайлан, зөвлөмжийг хүргүүлсэн боловч зөвлөмжийн биелэлт хугацаандаа хангагдаагүй байна.</p> <p>Зөвлөмжийг хэрэгжүүлэхгүй, он дамжин гарч, зөрчил давтагдсаар байна. Үүнд: Химийн лабораторийн ажиллагаа, химийн бодисын ашиглалт, хадгалалт бичиг баримт хөтлөлтөд 2024.08.25-нд хийсэн хяналт шалгалтаар өгсөн зөвлөмж нь 2025 онд мөн адил өгөгдсөн байна.</p> |

| | |
|--------------------------|---|
| | <p>Дотоод хяналтын алба 2025 онд 13 ажил төлөвлөсөн. 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 534 зөрчил илрүүлэн 387 зөрчлийг арилгаж, 147 зөрчил арилгах ажил хэрэгжих шатандаа байна.</p> <p>Нийлтэг илэрч буй зөрчлүүд:</p> <p>а) Дотоод хяналтын албанаас хяналт шалгалт хийж тайлан, зөвлөмжийг холбогдох алба, хэлтсүүдэд өгсөн боловч зөвлөмжийн биелэлт хангаж ажиллаагүй, биелэлтийг хугацаанд нь ирүүлээгүй байна. Мөн өмнөх онд өгсөн зөвлөмжөө хэрэгжүүлээгүйгээс шалтгаалж дараа онд мөн өгөгдөж байна.</p> <p>б) Хяналт шалгалтын тайлан, зөвлөмжийг харахад хөрөнгө санхүү, цаг хугацаа, ажилтны ур чадвараас шалтгаалан хойшлогдож, хэрэгжээгүй байна. Иймээс хөрөнгө санхүү, цаг хугацаа, албаны болон ажилтнаас шалтгаалсан эсэхийг ангилан эрэмбэлээгүйгээс хяналт, шалгалт нь үр дүнгүй болж байна.</p> <p>в) Компанийн дотоод бүтцийн албадууд нь дотоод хяналт шалгалтын зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэхгүй, алдаа зөрчлийг удаа дараа гаргаж, хариуцлагагүй ажиллаж байна.</p> |
| Шалгуур | <p>“МУ-ын ЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”;</p> <p>Гүйцэтгэх захирлын 2019.05.07-ний өдрийн А/78 дугаар тушаалаар батлагдсан “Дотоод хяналтын журам”;</p> |
| Асуудлын үндсэн шалтгаан | <p>Дээрх журмуудыг мөрдөж ажилдаггүй;</p> <p>Хяналт шалгалт өгсөн зөвлөмжийг холбогдох хэлтэс, алба нь хэрэгжилтийг хангадаггүй өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангалтгүй.</p> |
| Үр нөлөө | <p>Хэрэглэгчдийг найдвартай дулааны эрчим хүчээр хангах үндсэн зорилтын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй;</p> <p>Дотоод хяналт, шалгалт үр дүнгүй болох, алдаа зөрчил давтагдах.</p> |
| Зөвлөмж | <ol style="list-style-type: none"> 1. Гүйцэтгэх захирлын 2019 оны 05 дугаар сарын 07-ний өдрийн А/78 дугаар тушаалаар батлагдсан “Дотоод хяналтын журам”-ыг мөрдөж ажиллах; 2. Дотоод хяналтын алба нь хяналт шалгалтын төлөвлөгөөг гаргахдаа зөвлөмж, зөрчлийг ямар хугацаанд, хэрхэн яаж бүрэн арилгах талаар холбогдох судалгааг хийж, бодит байдалтай уялдуулан төлөвлөн гаргах; 3. Хяналт, шалгалтын мөрөөр өгсөн зөвлөмж аль хэлтэс, алба дээр ямар шалтгаанаас болж удааширч мөн хэрэгжихгүй байгаа асуудлыг судлан ангилан, эрэмбэлэх шаардлагатай; 4. Дотоод хяналт, шалгалтын мөрөөр өгсөн зөвлөмжийг хугацаанд нь шийдвэрлэж үр дүнгийн тайланг дотоод хяналтын хэлтэс хүргүүлж байх, хэрэгжилтийг удирдлагын зөвлөлд тогтмол танилцуулдаг байх; 5. Дотоод хяналтын зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй албан тушаалтанд хариуцлага ногдуулах талаар байгууллагын удирдлагад санал тавьж шийдвэрлүүлэх. |

4. ДҮГНЭЛТ

“Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-д гүйцэтгэсэн дотоод аудитын дүнд үндэслэн “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлтийг өгч байна.

ХЯНАСАН:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ,
дотоод аудитын газрын дарга

Х.Бекболат

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

ХШУДАГ-ын шинжээч

Н.Амартөвшин

ХШУДАГ-ын ахлах мэргэжилтэн

Т.Мөнхзул

ХШУДАГ-ын мэргэжилтэн

М.Оюундаваа

